



MNS ISO/IEC 17020:2013 стандартад итгэмжлэгдсэн байгууллага
РАДИО ДАВТАМЖ, ӨРГӨН НЭВТРҮҮЛГИЙН ХЯНАЛТЫН ТӨВ




**Хорооны даргын 2025 оны 05 дугаар сарын 23-ны өдрийн
A/128 тоот тушаалын дагуу хэмжилт, хяналтын тайлан**

Тайлангийн дугаар: Хяналт/2025/11


Хэвлэсэн огноо: 2025 он 06-р сарын 27-ны өдөр

1. Хэмжилтийн зорилго, хамрах хүрээ:
Хорооны даргын 2025 оны 05 дугаар сарын 23-ны өдрийн A/128 тоот тушаалын дагуу Монгол Улсын нутаг дэвсгэр дээгүүр дамжин өнгөрч байгаа улс хоорондын тээврийн хэрэгслүүдэд ашиглаж байгаа радио төхөөрөмжийн радио давтамжийн хэрэглээг тодорхойлох хэмжилт, хяналтыг хийж “Радио долгионы тухай хууль”, “Зөрчлийн тухай хууль” тогтоомжууд түүнтэй нийцүүлэн гаргасан дүрэм, журам, стандарт болон технологийн норм, горимыг мөрдүүлэх, хэрэгжүүлэх, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулахад оршино.
2. Хэмжилт хийсэн огноо, байршил, зураг:

№	Огноо	Хэмжилт хийсэн хаяг	Байршлын өргөрөг, уртраг
1	2025.05.26 –06.13–ны	Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг 32–р хороо, Баруун–түрүүн тээврийн пост	47°55'33.84"N, 106°37'16.52"E
2	хооронд	Улаанбаатар хот, Хан–Уул дүүрэг 14–р хороо, Өлзийт тээврийн пост	47°45'45.29"N, 106°45'2.95"E



Зураг 1. Хэмжилт, хяналт хийсэн байршил – Баруун–түрүүн тээврийн пост



Зураг 2. Хэмжилт, хяналт хийсэн байршил – Өлзийт тээврийн пост

3. Ашигласан хэмжүүрийн төхөөрөмж:

- Давтамж тоологч /SF-103/
- R&S FSH–20 спектр анализатор /1314.2000K30-120852-ht/
- HE–300 антены ком

4. Норматив бичиг баримт:

- Харилцаа холбооны тухай хууль
- Радио долгионы тухай хууль
- Зөрчлийн тухай хууль

5. Хэмжилтэд оролцсон бүрэлдэхүүн:

Хэмжилт хийж гүйцэтгэсэн			
№	Овог нэр	Байгууллага	Албан тушаал
1	А.Алтанхуяг	ХХЗХороо	Хөдөлгөөнт хяналтын ахлах инженер
2	М.Чагнаадорж	ХХЗХороо	Суурин хяналтын инженер
3	Ж.Дөлгөөн	ХХЗХороо	Суурин хяналтын инженер
4	М.Энхзориг	ХХЗХороо	Хөдөлгөөнт хяналтын инженер
5	Б.Бат-Эрдэнэ	ХХЗХороо	Хөдөлгөөнт хяналтын инженер
6	М.Мөнхбат	ХХЗХороо	Хөдөлгөөнт хяналтын инженер
7	Г.Билгүүдэй	ХХЗХороо	Техник хяналтын инженер
8	Д.Баярмаа	ХХЗХороо	Хөдөлгөөнт хяналтын инженер

Хэмжилтэд байлцсан		
№	Байгууллага	Албан тушаал
1	Тээвэр зуучийн албан байгууллага болон хувь хүмүүс	Жолооч нар
2	ЦЕГ-Экологийн цагдаагийн алба	Экологийн цагдаагийн албан хаагч нар

6. Хэмжилт хийх үеийн зураг:



Зураг 3. Баруун – түрүүн тээврийн пост



Зураг 4. Хэмжилт, хяналт хийж байх үеийн зураг

7. Хэмжилтийн дүн:

Баруун – түрүүн тээврийн пост болон Өлзийт тээврийн постуудаар нэвтрэн өнгөрсөн 84 тээврийн хэрэгсэлд хэмжилт, хяналт хийхэд харилцааны суурин станцыг 29 тээврийн хэрэгсэл ашиглаж байсан ба Радио долгионы тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 заалтыг зөрчсөн 10 байгууллага, 19 хувь хүн байв. Тоон үзүүлэлтийг графикаар харуулав.



Иргэн аж ахуйн нэгжүүд радио давтамж ашиглах эрхийн бичиг авахдаа дараах зөвлөмж хуудсанд заагдсан QR кодыг уншуулж видео заавар болон заавал бүрдүүлэх материалын жагсаалт бүхий цахим хуудсанд хандан мэдээлэл авна уу.



ХАРИЛЦАА ХОЛБООНЫ
ЗОХИЦУУЛАХ
ХОРОО

Харилцааны радио станц ашиглах зөвлөмж хуудас

Харилцаа Холбооны Зохицуулах Хорооны үндсэн үйл ажиллагааны нэг нь Монгол Улсын төрийн өмч, байгалийн хязгаарлагдмал нөөц болох радио долгионыг үндэсний хэмжээнд төлөвлөх, хуваарилах, түүний хяналт болон харилцаа холбооны тоног төхөөрөмжийг баталгаажуулах үйл явц юм.

Монгол улсын Радио долгионы тухай хуулийн 4.1-т Монгол улсын нутаг дэвсгэр дэх үүсгэгчээс үүссэн болон Үндэсний радио давтамжийн хуваарилалтын хүснэгтэд байгаа радио долгион нь **Монгол Улсын төрийн өмч** мөн гэж заасан.



Иргэн, хуулийн этгээд нь Радио төхөөрөмжийг радио давтамж ашиглах эрхийн бичиггүй хууль бусаар ашигласнаар харилцан нөлөөлөл үүсгэж хууль ёсны хэрэглэгчдийн хэвийн үйл ажиллагаанд саад учруулж ярианы чанар муудах, шуугиан үүсэж улмаар хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа алдагдаж үйлдвэрлэлийн осол гарах аюултай нөхцөл байдал үүсдэг. Мөн дараах хуулийн заалтуудыг зөрчиж байна. Үүнд:



Радио долгионы тухай хууль

7.1. Нийтийн хэрэглээний радио давтамжийн зурвасыг Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу байгуулагдаж, үйл ажиллагаа явуулж байгаа хуулийн этгээд, иргэн энэ хуулийн дагуу Зохицуулах хорооноос тусгай зөвшөөрөл, эрхийн бичиг авч, бүртгүүлж ашиглана.

8.1. Радио давтамж, радио давтамжийн зурвас ашиглах тусгай зөвшөөрөл, эрхийн бичиггүй этгээд радио давтамж, радио давтамжийн зурвас ашиглахыг хориглоно.

21.2 Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.



Радио давтамж ашиглах зөвшөөрөлтэй хэрэглэгчийн давуу тал:

- * Таны зөвшөөрөлтэй радио давтамжийг өөр байгууллага, хувь хүн давхар ашиглахгүй.
- * Гадна давхацсан яриа, шуугиан болон бусад радио төхөөрөмжүүдтэй харилцан нөлөөлөлд орсон тохиолдолд ХХЗХ-оос зөрчлийг арилгахыг шаардах эрхтэй.
- * Өөрийн сүлжээнд болон бусад радио төхөөрөмжүүдэд шуугиан үүсгэхгүй.



Иймд харилцааны радио станц ашиглах бол ХХЗХ-д хандаж Радио давтамж ашиглах **эрхийн бичиг** авч ашиглахыг зөвлөж байна.

Радио давтамж ашиглах, эрхийн бичиг авах бүрдүүлэх баримт бичигтэй QR кодыг уншуулж танилцана уу.



Хаяг:

Метро бизнес төв А-блок 5 давхар Д.Сүхбаатарын
гудамж-13 Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар 14201-0033

Радио давтамж ашиглах эрхийн бичиг авах видео зааврыг QR кодыг уншуулж танилцана уу.



Утас:

976-11-304258, 1800-1858

Имэйл:

info@crc.gov.mn